

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 1

Хуралдаан 2013 нэгдүгээр сарын 17-ны өдрийн 14 цаг 03 эхэлж, 16 цаг 22 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 19 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Уул уурхайн яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд Чулуунцэрэнгийн Отгочулууг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Жигжидэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Зам тээврийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар, Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга нарыг томилуулахаар нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн</p>

		<p>албаны зөвлөлийн 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Зам, тээврийн яамын Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд Батсүхийн Бямбажав, Зам, тээврийн яамын Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Даваанямын Батбаатар, Зам, тээврийн яамын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд Бадамын Махбал нарыг тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батзаяад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Үндэсний статистикийн хорооны Мэдээлэл, боловсруулалт технологийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Үндэсний статистикийн хорооны Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын даргын албан тушаалд Лхагваагийн Мягмарсүрэнг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Үндэсний Статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Ганбатад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

4	2001-2007 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхөөр ажиллаж байсан Я.Долгоржавыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>2001-2007 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхөөр томилогдон ажиллаж байсан Ядамын Долгоржавыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов</p>
5	Батлан хамгаалах яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	<p>Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 14 дүгээр тогтоолоор яамдын зохион байгуулалтын бүтцийг баталсантай холбогдуулан Батлан хамгаалах яамнаас ирүүлсэн саналыг Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 01 дүгээр сарын 17 -ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 126 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Батлан хамгаалах яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг шинэчлэн дараахь бүрэлдэхүүнтэй байгуулах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн нарийн бичгийн дарга, 2. Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, 3. Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, 4. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, 5. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, 6. Засгийн газрын тохируулагч

		<p>агентлаг Зэвсэгт хүчний Жанжин штабын дэд дарга, 7. Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, 8. Батлан хамгаалах их сургуулийн захирал, 9. Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн төлөвлөлтийн мэргэжилтэн.</p> <p>2.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 74 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын "Нэг"-ийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА